



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 11 сарын 02 өдөр

Дугаар А/749

Булган сум

Гамшгаас хамгаалах асуудал хариуцсан
ажилтанг томилон ажиллуулах үүрэг өгөх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.14 дэх заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1.Гамшгаас хамгаалах тухай хуулийн холбогдох заалт, Засгийн газрын зарим чиг үүргийг Булган аймагт 2023 онд төлөөлөн хэрэгжүүлэх гэрээ, Шадар сайд, аймгийн Засаг даргын хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг хангуулж тус аймагт Онцгой байдлын байгууллагын салбар, нэгжгүй сум, суурин газарт Засаг даргын Тамгын газрын аль нэг албан тушаалтанд гамшгаас хамгаалах асуудлыг хариуцуулан ажиллуулахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

2.Гамшгаас хамгаалах асуудлыг хариуцан ажиллаж байгаа албан тушаалтанд ажлын байрны тодорхойлолтод заагаагүй ажил үүрэг гүйцэтгэсний нэмэгдэл хөлсийг олгох асуудлыг хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ, хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу шийдвэрлэж ажиллахыг сумдын Засаг дарга нарт зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг сумдын Засаг дарга, Онцгой байдлын газрын дарга (хурандаа Ш.Баасандорж) нарт үүрэг болгосугай.

ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ

